

## МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2019 оны ... дугаар  
сарын ... ны өдөр

Улаанбаатар  
хот

### МОНГОЛ УЛСЫН ЗАСАГ ЗАХИРГАА, НУТАГ ДЭВСГЭРИЙН НЭГЖ, ТҮҮНИЙ УДИРДЛАГЫН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

**1 дүгээр зүйл.** Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуульд доор дурдсан агуулгатай дараах заалт нэмсүгэй:

#### **1/19 дүгээр зүйлийн 1 дэх хэсгийн 4 дэх заалт:**

“19.1.4.Худалдаа, үйлчилгээний төрөл, ангилал, худалдаа, үйлчилгээ эрхлэхэд тавигдах шаардлага, бүрдүүлэх баримт бичиг, худалдаа, үйлчилгээ эрхлэгчдийн эрх, үүргийг тодорхойлсон нийтлэг журам батлах;”

#### **2/29 дүгээр зүйлийн 1 дэх хэсгийн 6 дахь заалтын “м” дэд заалт:**

“29.1.6.”м”.Аймаг, нийслэл худалдаа, үйлчилгээний чиглэлээр иргэдийн Төлөөлөгчдийн Хуралдаанаар хэлэлцэх асуудлаар урьдчилан санал, дүгнэлт гаргах үүрэг бүхий орон тооны бус Худалдаа, үйлчилгээг зохицуулах зөвлөлтэй байж болно. Зөвлөлийн бүрэлдэхүүн, зохион байгуулалт, үйл ажиллагааны журмыг аймаг, нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал тогтооно.”

**2 дугаар зүйл.** Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 19 дүгээр зүйлийн “19.1.4” гэснийг “19.1.5” гэж өөрчилсүгэй.

Гарын үсэг

Төсөл

**МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ**

2019 оны ... дугаар  
сарын ... ны өдөр

Улаанбаатар  
хот

**ОРОН СУУЦНЫ ТУХАЙ ХУУЛЬД  
НЭМЭЛТ ОРУУЛАХ ТУХАЙ**

**1 дүгээр зүйл.**Орон сууцны тухай хуульд доор дурдсан агуулгатай дараах заалт нэмсүгэй:

**1/3 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 11, 12, 13 дахь заалт:**

“3.1.11.”нийтийн байр” гэж өөрийн эзэмшлийн 5-аас дээш өрөө бүхий хүн амьдран суух зориулалтаар ашиглуулж байгаа барилгыг;”

“3.1.12.”нийтийн байрны үйлчилгээ эрхлэгч” гэж өөрийн эзэмшлийн барилгыг бусдад гэрээний үндсэн дээр ашиглуулж байгаа иргэн, хуулийн этгээдийг;”

“3.1.13.”нийтийн байр ашиглагч” гэж нийтийн байр /нэг болон түүнээс дээш өрөө/-ыг гэрээний үндсэн дээр ашиглаж байгаа иргэн, хуулийн этгээдийг.”

**2/8 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 4 дэх заалт:**

“8.1.4.Нийтийн байрны үйлчилгээ эрхлэхэд дагаж мөрдөх журмыг аймаг, нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал баталж, хэрэгжилтэд хяналт тавих.”

Гарын үсэг